

ТӨСӨЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2018 оны дугаар
хамтарсан тушаалын Нэгдүгээр хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГАД ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хүнд үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, чанар, стандартыг сайжруулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжийн нэвтрүүлж, нутагшуулсан технологийн боловсруулалтын түвшний үнэ цэнэ /өртөг/-г тодорхойлоход чиглэсэн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээ хийх эрх бүхий байгууллагад аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох зөвшөөрөл олгоход энэхүү журмыг баримтална.
- 1.2. Хүнд үйлдвэрийн салбарын технологийн түвшний үнэлгээ /цаашид “Үнэлгээ” гэх/ нь иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж буй хүнд үйлдвэрийн салбарын технологийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, үр ашгийг нэмэгдүүлэх, технологийн түвшинг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.3. Үйлдвэрлэл, технологийн парк, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.1.2-т заасан дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгж нь үнэлгээг хийлгэсэн байна.

Хоёр. Хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

- 2.1. Үйлдвэрлэлийн технологийн түвшинг үнэлэх, үнэлгээ хийх эрх бүхий байгууллагад зөвшөөрөл олгох, технологийн нэгдсэн бүртгэлийн сангийн чиглэлээр хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх:
 - 2.1.1. үнэлгээ хийх эрх бүхий байгууллагад холбогдох зөвшөөрлийг олгох, цуцлах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллуулах;
 - 2.1.2. аж ахуйн нэгжийн өөрийн нэвтрүүлсэн, нутагшуулсан технологи, оюуны өмч, судалгаа хөгжлийн зардал, технологийн шинэчлэлийн талаарх мэдээллийн санг үүсгэх;
 - 2.1.3. үнэлгээ хийх эрх авах шаардлага хангасан эрдэм шинжилгээний байгууллагын нэгдсэн жагсаалтыг гаргах, нийтэд зарлах, үнэлгээний нэгдсэн сан үүсгэх;
 - 2.1.4. үнэлгээ хийх эрх авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 2.1.5. бусад эрх, үүрэг;

Гурав. Үнэлгээний байгууллагын эрх үүрэг, тавигдах шаардлага

- 3.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан эрдэм шинжилгээний байгууллагад Технологи дамжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн

7.7-д заасан журам, аргачлалын дагуу үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг олгоно.

3.2. Үнэлгээ хийх эрх бүхий байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. үнэлгээний онол, арга зүйн мэдлэгийг эзэмшсэн, хүнд үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 3 буюу түүнээс дээш тооны докторын зэрэгтэй эрдэмтэн судлаачтай байх;

3.2.2. тухайн чиглэлийн зөвлөх инженертэй байх;

3.2.3. тухайн чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн онцлог байдал, уг чиглэлээр туршлага хуримтлуулсан, шинэ бүтээл, оновчтой саналууд гарган нэвтрүүлж байсан эрдэмтэн, мэргэжилтэнтэй байх,

3.2.4. тухайн чиглэлийн технологийн түвшний үнэлгээг хийж гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, хэмжилт судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

3.2.5. нийт ажиллагсдын гуравны хоёроос доошгүй нь орон тооны мэргэжлийн боловсон хүчин байх;

3.3. Үнэлгээ хийх эрх бүхий байгууллага нь тухайн технологийн болон иргэн, аж ахуйн нэгжийн нууцад хамаарах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу чандлан хадгалах үүрэг хүлээх бөгөөд гүйцэтгэсэн үнэлгээний талаар тайлан, дүгнэлт гаргаж баталгаажуулна.

3.4. Тухайн үйлдвэрлэлийн чиглэл, онцлог байдлаас хамааран үнэлгээ хийх байгууллагад нарийн мэргэжлийн эрдэмтэн, мэргэжилтэн дутагдвал тэднийг өөр байгууллагаас гэрээний үндсэн дээр авч ажиллуулж болно.

Дөрөв. Үнэлгээ хийх байгууллагад эрх олгох, бүртгэх, хугацааг сунгах

4.1. Энэхүү журмын 2.1.1-д заасан зөвлөл нь журмын 3.2-д заасан шаардлага хангасан байгууллагад үнэлгээ хийх эрх олгосон зөвшөөрлийн гэрчилгээ олгож технологийн бүртгэлийн нэгдсэн санд бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

4.2. Үнэлгээ хийх эрх авах хүсэлт гаргагч нь энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу материал бүрдүүлэн зөвлөлд өргөдөл гаргана. Өргөдлийг тогтмол хүлээж авах ба ажлын 15 өдөрт багтаан үнэлгээ хийх эрхийг олгох эсэхийг шийдвэрлэж, зөвшөөрлийн гэрчилгээ олгоно. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг дахин 15 хоногоор сунгаж болно.

4.3. Үнэлгээ хийх эрх олгосон зөвшөөрлийн гэрчилгээний загвар, гэрчилгээний хураамжийн хэмжээг хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.4. Үнэлгээ хийх эрх олгосон зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа 3 /гурван/ жил байх бөгөөд сунгалтыг 3 /гурван/ жилээр хийж баталгаажуулна.

4.5. Сунгалт хийлгэх хүсэлт гаргагч нь зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дуусахаас 2-оос доошгүй сарын өмнө хугацаа сунгуулах тухай өргөдлийг холбогдох материалын

хамт зөвлөлд ирүүлнэ. Өргөдлийг зөвлөл хянан үзэж, үйл ажиллагааны тайлан, үр дүнг харгалзан хугацааг сунгах эсэх талаар шийдвэр гаргана.

Тав. Үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээг тооцох

5.1. “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй болон нэвтрүүлж, нутагшуулсан үйлдвэрлэлийн технологийн түвшинд үнэлгээ хийх аргачлал”-ыг хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.2. Үнэлгээ хийх эрх бүхий байгууллага нь үйл ажиллагаанд энэхүү журмын 5.1-д заасан аргачлалыг мөрдлөг болгон ажиллана.

Зургаа. Үнэлгээ хийх байгууллагын эрхийг цуцлах

6.1. Зөвлөл нь дараах тохиолдолд үнэлгээ хийх эрх бүхий байгууллагын үнэлгээ хийх эрхийг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгоно:

6.1.1. энэхүү журмын 3.2-д заасан шаардлагыг хангаагүй;

6.1.2. үнэлгээг энэхүү журмын 5.1-д заасан аргачлалын дагуу хийгээгүй эсвэл бүрэн бус, буруу хийсэн, мэргэжлийн ёс зүйг ноцтой зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан нь холбогдох хууль тогтоомжоор тогтоогдсон бол;

6.1.3. үнэлгээ хийх эрх олгосон зөвшөөрлийн гэрчилгээний хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сунгуулаагүй;

Долоо. Бусад зүйл

7.1. Журмын хэрэгжилтэд хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж хяналт тавьж ажиллана.

7.2. Журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2016 оны дугаар
хамтарсан тушаалын Хоёрдугаар
хавсралт

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГАД
ЭРХ ОЛГОХ МАТЕРИАЛЫН БҮРДҮҮЛБЭР**

1. Эрх авахаар гаргасан хүсэлт /албан бичиг/
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан/
3. Аж ахуйн нэгжийн товч танилцуулга
4. Докторын зэрэгтэй эрдэмтэн судлаачдын анкет, дипломын хуулбар /нотариатаар батлуулсан/
5. Зөвлөх инженерийн анкет, үнэмлэхний хуулбар /нотариатаар батлуулсан/
6. Шинэ бүтээл, оновчтой саналуудын танилцуулга
7. Ажлын байр /түрээсийн гэрээний хуулбар/, хэмжилт судалгааны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, фото зураг, танилцуулга
8. Орон тооны мэргэжлийн боловсон хүчний мэргэжил, ур чадварыг нотлох бичиг баримт, хөдөлмөрийн гэрээ.